



## ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

### Замын зураглал, төлөвлөгөө батлах тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 11.1.4, Улсын Их Хурлын 2009 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ын 7.1, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 3.6, 4.1.2, 4.1.7, Цөмийн энергийн комиссын дэргэдэх Цацрагийн аюулгүйн зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 23-01 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Цөмийн аюулгүй байдлыг хангах замын зураглал”-ыг 1 дүгээр, “Цөмийн аюулгүй байдлыг хангах замын зураглалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төлөвлөгөө батлах тухай” Цөмийн энергийн комиссын 2015 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

3100067

Цөмийн энергийн комиссын 2023 оны дугаар сарын 2-ны өдрийн 07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



## ЦӨМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

### НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖ, ХЯНАЛТЫН ТОГТООЦОО

Зорилго 1.А. - Цөмийн аюулгүй байдалтай холбоотой олон улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, үндэсний хууль тогтоомжийг батлах:

Арга хэмжээ	Хариуцах, үүрэг бүхий байгууллага	Явц	Төлөвлөсөн хугацаа	Тайлбар
1.А.1 Цөмийн материалыг биеллэн хамгаалах тухай конвенц (СРРNM)-д нэгдэн орох, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах;	Монгол Улсын Засгийн газар	Биелсэн	Биелсэн	<ul style="list-style-type: none"><li>Монгол Улс Цөмийн материалыг биеллэн хамгаалах тухай конвенцод 1986 онд нэгдэн орсон.</li></ul>
1.А.2 Цөмийн материалыг биеллэн хамгаалах тухай конвенцын нэмэлт (А/СРРNM)-д нэгдэн орох, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах;	Тэргүүлэх байгууллага: БШУЯ, ЦЭК; Бусад хариуцах байгууллага: Монгол Улсын Засгийн газар, ГХЯ, ХЗДХЯ;	Хэрэгжиж байгаа	2024	<ul style="list-style-type: none"><li>Монгол Улс Цөмийн материалыг биеллэн хамгаалах тухай конвенцын нэмэлтэд ажиглагчийн статустай оролцдог.</li><li>Улсын Их хурлын 2015 оны 60 дугаар тогтоолд Цөмийн материалыг биеллэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.</li><li>ЦЭК болон БШУЯ-наас нэмэлтэд нэгдэн орох тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлуулсан.</li><li>2023 онд Засгийн газарт болон Улсын Их Хурлын Байнгын Хороонд өргөн барьж, 2024 онд нэгдэн орохоор төлөвлөж байна.</li><li>ГХЯ-наас А/СРРNM-д нэгдэн орох саналыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн.</li><li>2018 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Япон Улсын Токай хотод зохион байгуулагдсан А/СРРNM-ийн бүсийн семинар Монгол Улс оролцсон.</li></ul>

						<ul style="list-style-type: none"> <li>• 2021 оны 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулагдсан Цөмийн материалын биет хамгаалалтад СРРНИ-ийн оролцоо сэдэвт Төв Ази, Европын бүсийн бага хуралд Монгол Улс оролцсон.</li> <li>• 2022 оны 10 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд БНСВУ-ын Ханой хотод зохион байгуулагдсан АСРРНИ-ийн семинарт Монгол Улс оролцсон.</li> <li>• 2021 онд оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх бүсийн уулзалт зохион байгуулагдсан.</li> <li>• Монгол Улс Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын нэмэлт (А/СРРНИ)-д нэгдэн орох үйл явцаа үргэлжлүүлж, ОУАЭА-аас шаардлагатай дэмжлэгийг авна.</li> <li>• Монгол Улс Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенцод 1987 онд нэгдэн орсон.</li> </ul>
1.А.3	Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенцод нэгдэн орох, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах;	Монгол Улсын Засгийн газар	Биелсэн	Биелсэн		<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улс Цөмийн осол гарсан буюу цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенцод нэгдэн орох, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах;</li> </ul>
1.А.4	Цөмийн осол гарсан буюу цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенцод нэгдэн орох, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах;	Монгол Улсын Засгийн газар	Биелсэн	Биелсэн		<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улс Цөмийн осол гарсан буюу цацрагийн аюулгүй байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенцод 1987 онд нэгдэн орсон.</li> </ul>
1.А.5	Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенцод нэгдэн орох, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах;	Монгол Улсын Засгийн газар	Биелсэн	Биелсэн		<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улс Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенцод 2006 онд нэгдэн орсон.</li> </ul>
1.А.6	Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай олон улсын конвенцод нэгдэн орох, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах;	Монгол Улсын Засгийн газар	Биелсэн	Биелсэн		<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улс Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай олон улсын конвенцод 2000 онд нэгдэн орсон.</li> </ul>
1.А.7	НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 дугаар тогтоол – Террорист үйлдлээс олон улсын энх тайван аюулгүй байдлын эсрэг аюул заналтай холбоотой үүрэг хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид тусгах;	Терроризмтэй тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газар	Хэрэгжиж байгаа	-		<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 (2001) дугаар тогтоолын хүрээнд 2001, 2002, 2005 онуудад тайлан хургуулсан.</li> <li>• Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 247 дугаар тогтоолоор НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг баталсан.</li> </ul>

1.A.8	НУБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дугаар тогтоол – Үй олноор хөнөөх зэвсгийг үл дэлгэрүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид тусгах;	Тэргүүлэх Байгууллага: Терроризмтэй тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газар; Бусад хариуцах Байгууллага: ЦЭК, холбогдох яам, агентлагууд	Биелсэн	Биелсэн	<ul style="list-style-type: none"> <li>НУБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний төлөвлөгөөг 2022 онд баталсан.</li> <li>Монгол Улс НУБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дүгээр тогтоолын хүрээнд 2005 оны 05 дугаар сар болон 2014 оны 04 дүгээр сард тус тус тайлан хургуулсан.</li> <li>Төлөвлөгөөний хүрээнд хилгийн хяналтын төхөөрөмжүүдийг суурилуулсан.</li> <li>Хамаарал бүхий хууль тогтоомж: Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай, Мөнгө угаахтай тэмцэх тухай, Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль зэрэг болно.</li> <li>Монгол Улс Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай 1988 оны олон улсын конвенц, түүний протоколд элсэн орсон. 2005 оны Бээжингийн конвенц болон түүний нэмэлтэд нэгдэн ороогүй байна.</li> <li>ОУАЭА-ийн Хуулийн хэлтсээс 2005 оны Бээжингийн конвенц болон түүний нэмэлтэд нэгдэн ороход шаардлагатай олон улсын эрх зүйн орчин болон үндэсний мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх боломжтой.</li> </ul>
1.A.9	Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц, түүний протоколууд болон Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц зэрэг Цөмийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой олон улсын заавал дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орох, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах;	ЦЭК/Монгол Улсын Засгийн газар	1. Биелсэн 2. Хэрэгжиж байгаа (SUA 2005 Protocol and Beijing Convention)	Тодорхой болгох	<ul style="list-style-type: none"> <li>ОУАЭА болон бусад олон улсын байгууллагуудтай хамтран мэдлэг дээшлүүлэх ажлыг удирдах албан тушаалтнуудад зохион байгуулж, конвенц, хууль эрх зүйн баримт бичгийн мөн чанарыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.</li> <li>ОУАЭА-аас 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын холбогдох байгууллагуудын шийдвэр гаргах түвшний албан хаагчдад цөмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох үндэсний семинарыг зохион байгуулсан.</li> <li>ОУАЭА-ийн Хуулийн хэлтсээс үндэсний болон олон улсын хууль эрх зүйн орчныг олон нийтэд таниулахтай холбоотой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой.</li> </ul>
1.A.10	Засгийн газрын дээд түвшний албан тушаалтнууд болон хууль тогтоогч нарт цөмийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой олон улсын хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэгч олон улсын эрх зүйн баримт бичгийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх үүлзэлт, зөвлөгөөн, танилцуулах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;	Тэргүүлэх Байгууллага: ЦЭК; Бусад хариуцах Байгууллага: БШУЯ, ГХЯ, УИХ-ын Тамгын газар, ОУАЭА-тай хамтран оролцоно.	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>ОУАЭА болон бусад олон улсын байгууллагуудтай хамтран мэдлэг дээшлүүлэх ажлыг удирдах албан тушаалтнуудад зохион байгуулж, конвенц, хууль эрх зүйн баримт бичгийн мөн чанарыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.</li> <li>ОУАЭА-аас 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын холбогдох байгууллагуудын шийдвэр гаргах түвшний албан хаагчдад цөмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох үндэсний семинарыг зохион байгуулсан.</li> <li>ОУАЭА-ийн Хуулийн хэлтсээс үндэсний болон олон улсын хууль эрх зүйн орчныг олон нийтэд таниулахтай холбоотой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой.</li> </ul>

## Зорилго 1.Б – Заавал дагаж мөрдөх шаардлагагүй олон улсын эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөх

Арга хэмжээ	Харуцах, үүрэг бүхий байгууллага	Явц	Төлөөлсөн хугацаа	Тайлбар
<b>1.Б.1</b> “Цөмийн материал болон цөмийн байгууламжийн биет хамгаалалт” баримт бичгийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх (IAEA-INFСІRC/225/Rev 5.);	Тэргүүлэх Байгууллага: ЦЭК	Биелсэн	Биелсэн	<ul style="list-style-type: none"> <li>“Уран болговсруулах үйлдвэрийн цөмийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж”-ийг 2019 онд баталсан. Энэхүү зөвлөмжид СРРNM болон “IAEA-INFСІRC/225/Rev 5” зөвлөмжид тусгагдаагүй “Менэжментийн зохистой үйл ажиллагаа” зэрэг асуудлуудыг тусгаж өгсөн байдаг.</li> </ul>
<b>1.Б.2</b> а. “Цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг зохицуулах дүрэм”-д тусгагдсан заавруудыг мөрдлөг болгох;	Тэргүүлэх Байгууллага: ЦЭК	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрмийг Цөмийн энергийн комиссын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан.</li> <li>Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийг Цөмийн энергийн комиссын 2016 оны 1 дүгээр тогтоолоор баталсан.</li> <li>Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх дүрэм”-ийг Засгийн газрын 2019 оны 243 дугаар тогтоолоор баталсан.</li> <li>Монгол Улс ОУАЭА-ийн “Цацраг идэвхт үүсгүүр аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг зохицуулах дүрэм”-ийг дэмжих тухай албан ёсны байр суурийг ОУАЭА-т илгээх боломжтой.</li> <li>Дэмжих тухай албан ёсны байр суурийг илэрхийлэх захидлын маягтыг дараах холбоосоор татаж авах боломжтой.  <a href="https://nucleus.iaea.org/sites/ns/code-of-conduct-radioactive-sources/Documents/Letter%20of%20political%20support%20.pdf">https://nucleus.iaea.org/sites/ns/code-of-conduct-radioactive-sources/Documents/Letter%20of%20political%20support%20.pdf</a></li> <li>ОУАЭА-аас 2022 оны 08 дугаар сарын 30-наас 09 дүгээр сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан “Цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг зохицуулах дүрэм”-ийн таниулах үйлзэлтэд Монгол Улс оролцсон.</li> <li>Монгол Улс цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын ... дүрмийг ОУАЭА-</li> </ul>
б. “Цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг зохицуулах дүрэм”-ийн заалтуудыг үндэсний хууль тогтоомж, дүрэм журамд тусгах;	Тэргүүлэх Байгууллага: ЦЭК	Биелсэн	Биелсэн	

Албан хэрэгцээнд

				ийн холбогдох дүрмүүдэд үндэслэн боловсруулж батлуулсан.
<b>1.Б.3</b> а. Зохицуулах дүрмийн "Цацраг идэвхт үүсгүүрийн импорт болон экспортын нэмэлт заавар"-т тусгагдсан заавруудыг мөрдлөг болгох;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс "Цацраг идэвхт үүсгүүрийн импорт болон экспортын нэмэлт заавар"-ыг дэмжих тухай албан ёсны байр суурийг ОУАЭА-т илтгэх боломжтой.</li> <li>1.Б.2-т заасан холбоосоор дамжуулан уг маягтыг авах боломжтой.</li> <li>2023 оны 01 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод зохион байгуулагдсан олон улсын уулзалтад оролцсон.</li> </ul>
<b>1.Б.4</b> а. Зохицуулах дүрмийн "Ашиглагдахгүй болсон цацраг идэвхт үүсгүүрийн менежментийн нэмэлт тусгагдсан заавруудыг мөрдлөг болгох; б. "Ашиглагдахгүй болсон цацраг идэвхт үүсгүүрийн менежментийн нэмэлт заавар"-ын заалтуудыг үндэсний хууль тогтоомж, дүрэм журамд тусгах;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс "Ашиглагдахгүй болсон цацраг идэвхт үүсгүүрийн менежментийн нэмэлт заавар"-ыг дэмжих тухай албан ёсны байр суурийг ОУАЭА-т илтгэх боломжтой.</li> <li>1.Б.2-т заасан холбоосоор дамжуулан уг маягтыг авах боломжтой.</li> <li>"Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг Засгийн газрын 2022 оны 445 дугаар тогтоолоор баталсан.</li> </ul>

**Зорилго 1.В – Цөмийн аюулгүй байдлын хууль тогтоомж, хяналтын тогтолцоог бий болгож, тогтмол хянаж, шинэчлэх**

<b>Арга хэмжээ</b>	<b>Харууцах, үүрэг бүхий байгууллага</b>	<b>Явц</b>	<b>Төлөөлсөн хугацаа</b>	<b>Тайлбар</b>
<b>1.В.1</b> а. Цөмийн аюулгүй байдлын үндэсний дэглэмийг тодорхойлохын тулд одоо мөрдөгдөж байгаа үндэсний хууль тогтоомж, хяналтын тогтолцоо, захиргааны арга хэмжээний талаар хийдлийн шинжилгээ хийх;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, ХЗДХЯ, Бусад харууцах байгууллага:	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу шинээр батлах хуулийн төсөлд хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа, үр нөлөөллийн шинжилгээ, зардлын тооцоо хийх шаардлага тавигддаг.</li> <li>Цөмийн энергийн тухай хууль (2009 оны 07 дугаар сарын 19-нд батлагдсан)-д нэмэлт өөрчлөлт</li> </ul>

	Холбогдох яам, агентлагууд			<p>орлуулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Дээрх судалгаануудыг хийж, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Цөмийн энергийн тухай хуулийн 32.1, 32.2-т Биет хамгаалалттай холбоотой заалтуудыг тусгасан.</li> <li>• Хамаарал бүхий хууль тогтоомж: Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль зэрэг болно.</li> <li>• Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 онд батлагдсан.</li> <li>• <a href="https://mfa.gov.mn/en/documentation/55280/">https://mfa.gov.mn/en/documentation/55280/</a></li> <li>• Хууль болон дагалдах дүрэм журамд 4 жил тутамд хийдлийн шинжилгээ хийх боломжтой.</li> </ul>
<p>б. Шаардлагатай тохиолдолд цөмийн аюулгүй байдлын захиргааны арга хэмжээтэй холбоотой анхны/орхигдсон эсвэл нэмэлт хууль, дүрэм журмыг боловсруулах;</p>	<p>Тэргүүлэх байгууллага: ЦЭК, ХЗДХЯ; Бусад хармуцах байгууллага: Холбогдох яам, агентлагууд; ОУАЭА-ийн Хуулийн хэлтэс болон Цөмийн аюулгүй ажиллагаа, цөмийн аюулгүй байдлын газрын боломжит дэмжлэгээр</p>	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улс ОУАЭА-ийн Хуулийн хэлтэстэй хууль эрх зүйн хүрээнд дэмжлэг авах ажлын төлөвлөгөөтэй.</li> <li>• Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, үнэлгээ хийхэд ОУАЭА-ийн Хуулийн хэлтэс хамтран ажиллах боломжтой. Хуулийн төслийг ОУАЭА-ийн Хуулийн хэлтэст хүргүүлж санал авах боломжтой.</li> <li>• ОУАЭА-аас 2022 оны 08 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд БНСВУ-ын Ханой хотод зохион байгуулагдсан Цөмийн хуулийн бүсийн семинарт Монгол Улсаас хуулийн мэргэжилтэн оролцсон.</li> <li>• 2023 оны 08 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотноо ОУАЭА-аас зохион байгуулах "Цөмийн аюулгүй байдлын дүрэм журам боловсруулах, холбогдох захиргааны арга хэмжээ" сэдэвт сургалтад холбогдох албан хаагчийг оролцуулах боломжтой.</li> </ul>

1.В.2		Тэргүүлэх байгууллага: Монгол Улсын Засгийн газар, ЦЭК,	Биелсэн	Биелсэн	
<p>а. Цөмийн аюулгүй байдлалтай холбоотой асуудлыг хариуцах тодорхой чиг үүрэг бүхий үндэсний эрх бүхий байгууллагуудыг тодорхойлон, томилж, эрх үүрэг олгох;</p>	<p>Бусад хариуцах Байгууллага: Холбогдох яам, агентлагууд</p>			<ul style="list-style-type: none"> <li>• Холбогдох хууль тогтоомжоор УАБЗ, ЦЭК, БШУЯ, ОБЕГ, ТЕГ, ЗХЖШ, ЦЕГ, ТТЗ, ХХЕГ, ГЕГ зэрэг байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон.</li> <li>• Цөмийн энергийн тухай хуулиар тусгай зөвшөөрөлтэй байгууллагын үүрэг хариуцлагуудыг тодорхойлж өгсөн байдаг. Үндэ: <ul style="list-style-type: none"> <li>○ Цөмийн энергийн комисс - Цөмийн төхөөрөмж, цөмийн бодистой холбогдсон үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох;</li> <li>○ Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага - Цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох;</li> <li>○ Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага - Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох;</li> </ul> </li> <li>• Цөмийн аюулгүй байдлыг хангах хүрээнд дараах байгууллагууд үүрэг хүлээнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>○ Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар - Цөмийн аюулгүй байдлалтай холбоотой олон улсын эрх зүйн баримт бичигт нэгдэн орохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх, хуулийн төслүүдийг хэлэлцэн батлах, НУБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангах;</li> <li>○ УАБЗ - Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах;</li> <li>○ ТТЗ - НУБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дүгээ тогтоолын хэрэгжилтийг хангуулах;</li> <li>○ ЦЭК - Цөмийн аюулгүй байдлалтай холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, холбогдох дүрэм журмыг батлах;</li> <li>○ БШУЯ - Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</li> <li>○ ЦЭК, холбогдох яам, агентлагууд - Цөмийн аюулгүй байдлалтай холбоотой заалт, дүрэм,</li> </ul> </li> </ul>	

	<p>6. Эдгээр үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд хангалттай эрх мэдэл, санхүү, хүний болон техникийн нөөц, үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах;</p>	<p>Тэргүүлэх байгууллага: Монгол Улсын Засгийн газар, ЦЭЖ;</p> <p>Бусад хариуцах байгууллага: Холбогдох яам, агентлагууд</p>	Тогтмол	Тогтмол	<p>журам, хуулийн хариуцлагын тогтолцоо, арга хэмжээг тусгасан үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тогтмол хяналт тавьж сайжруулах, хяналтын тогтолцоог бий болгох;</p> <ul style="list-style-type: none"> <li>1.В.1-д заасан хийдлийн шинжилгээг хийж, бусад боломжит оролцогч талуудын үүрэг хариуцлагын хийдлийг тодорхойлох боломжтой.</li> <li>ХХЕГ, ГЕГ-г өөрсдийн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд нөөц дутмаг байдаг.</li> <li>1.В.1-д заасан хийдлийн шинжилгээгээр үүрэг хариуцлагыг тодорхойлох боломжтой.</li> </ul>
<p><b>1.В.3</b></p>	<p>Цөмийн аюулгүй байдлыг зохицуулах байгууллага буюу механизмыг бий болгох, зохих зохицуулалт, харилцаа холбоог хангах бусад арга хэмжээг авах:</p> <p>а. Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа</p> <p>б. Эрх бүхий байгууллага болон эрх бүхий этгээд хоорондын хамтын ажиллагаа</p>	<p>Тэргүүлэх байгууллага: ЦЭЖ;</p> <p>Бусад хариуцах байгууллага: УАБЗ, ТТЗ, холбогдох яам, агентлагууд</p>	Тогтмол	Тогтмол	<ul style="list-style-type: none"> <li>ЦЭЖ нь цөмийн аюулгүй байдлын асуудлаар үндэсний зохицуулах байгууллага байна.</li> <li>Тогтвортой байдлыг хангах зорилгоор тусгай ажлын хэсгийг байгуулах боломжтой.</li> </ul>
<p><b>1.В.4</b></p>	<p>Тусгай зөвшөөрөл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах арга хэмжээ авах, хариуцлага тооцох;</p>	<p>Тэргүүлэх байгууллага: БШУЯ;</p> <p>Бусад хариуцах байгууллага: ЦЭЖ</p>	Биелсэн	Биелсэн	<ul style="list-style-type: none"> <li>БШУЯ нь аюулгүй ажиллагаа болон биет хамгаалалтын чиглэлээр хяналт шалгалт хийх үүрэгтэй. БШУЯ-наас жил бүр хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, зарим тохиолдолд цагдаа болон тагнуулын байгууллагатай хамтран хяналт шалгалтыг гүйцэтгэдэг. Хяналт шалгалтыг хяналтын хуудасны дагуу гүйцэтгэдэг.</li> <li>Цөмийн энергийн тухай хуулийн 32.2-т "Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагааны биет хамгаалалтад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын байцаагч хяналт тавьж, үнэлгээ хийнэ." гэж заасан байдаг.</li> </ul>

<b>1.В.5</b>	Тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эсвэл олгогдсон зөвшөөрөл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулж мөрдүүлэх, зөрчсөн тохиолдлуудад зохих хариуцлага хүлээлгэх;	Тэргүүлэх байгууллага: ХЗДХЯ	Биелсэн	Биелсэн	<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүгийн хуульд зааснаар БШУЯ, цагдаагийн байгууллага хариуцлага, шийтгэл ногдуулах эрхтэй.</li> <li>• Эрүүгийн хуульд зааснаар гаалийн байгууллага хууль бус тээвэрлэлтэд хариуцлага, шийтгэл ногдуулах эрхтэй.</li> <li>• Гаалийн байгууллага нь тухайн бараа импортын зөвшөөрөлтэй (жишээ нь изотопын төрөл гэх мэт) нийцэж байгаа эсэхийг шалгах эрхтэй.</li> <li>• Дараах хуулийг баримтлах боломжтой. Үнд: Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Гүйцэтгэх ажиллагааны тухай хууль зэрэг болно.</li> </ul>
<b>1.В.6</b>	Үндэсний хууль тогтоомжид тусгагдсан Цөмийн аюулгүй байдлыг хангах заалтуудыг хангахын тулд хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, түүнчлэн зохих хамгаалалт, хяналтыг баталгаажуулах хууль сахиулах тогтолцоо, арга хэмжээг тогтмол хянаж, шинэчлэх;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, ХЗДХЯ; Бусад хариуцах байгууллага: холбогдох яам, агентлагууд	Тогтмол	Тогтмол	<ul style="list-style-type: none"> <li>• 1.В.1-ийг харах</li> </ul>

### ХОЁР. АЮУЛ ЗАНАЛ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

#### Зорилго 2.А – Аюул занал, эрсдэлийн үнэлгээг хийх

<b>2.А.1</b>	<b>Арга хэмжээ</b>	<b>Хариуцах, үүрэг бүхий байгууллага</b>	<b>Явц</b>	<b>Төлөөлөгсөн хугацаа</b>	<b>Тайлбар</b>
	Дотоод хүчин зүйл (дотоод аюул занал)-ийг багтаасан цөмийн аюулгүй байдлын аюул заналыг тодорхойлж үнэлэх: а. Хяналтад байгаа материалын хувьд б. Хяналтаас гадуурх материалын хувьд в. Олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээний хувьд	Тэргүүлэх байгууллага: ЦЭК; Бусад хариуцах байгууллага: ТЕГ, ЦЕГ болон бусад хууль	Харэгжиж байгаа	2024	<ul style="list-style-type: none"> <li>• 2017 оны 08 дугаар сард ОУАЭД-ийн экспертүүдтэй хамтран загварт суурилсан аюул заналын үнэлгээний семинарыг зохион байгуулсан. Семинарын дараагаар төрийн байгууллагуудтай хамтран үнэлгээг гүйцэтгэсэн.</li> <li>• Үнэлгээнд хяналтаас гадуурх үүсгүүрийн талаарх асуудлыг хамруулаагүй.</li> </ul>

	г. Цөмийн эрчим хүчний хөтөлбөрийг бий болгох хүрээнд	сахиулах байгууллагууд			<ul style="list-style-type: none"> <li>• 2019 оны 11 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан "Загварт суурилсан аюул заналын үнэлгээ" сэдэвт бүсийн семинарт Монгол Улс оролцсон.</li> <li>• Ойрын жилүүдэд аюул заналын үнэлгээг цогц байдлаар хийж шинэчлэх шаардлагатай.</li> <li>• 3.А.2-ыг харах</li> </ul>
2.А.2	Зорилгот болон боломжит үр дагаврыг тодорхойлж, үнэлэх: а.Хяналтад байгаа материалын хувьд б.Хяналтаас гадуурх материалын хувьд в.Олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээний хувьд г. Цөмийн эрчим хүчний хөтөлбөрийг бий болгох хүрээнд	Тэргүүлэх байгууллага: ЦЭК;  Бусад хариуцах байгууллага: ТEG, ЦEG болон бусад хууль сахиулах байгууллагууд	Хэрэгжиж байгаа	2024	<ul style="list-style-type: none"> <li>• 2.А.1-ийг харах.</li> <li>• ОУАЭА-аас 2023 оны IV улиралд Исламын Бүгд Найрамдах Лакистан Улсын Равалпинди хотод зохион байгуулагдах "Загварт суурилсан аюул заналын үнэлгээ" сэдэвт бүсийн семинарт оролцох боломжтой.</li> <li>• Аюул заналын үнэлгээг дахин хийх хүрээнд холбогдох албан хаагчдад мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор үндэсний семинарыг ОУАЭА-тай 2024 онд зохион байгуулах боломжтой.</li> </ul>
2.А.3	<b>Хяналтад байгаа материалын хувьд:</b> Тодорхойлсон аюул заналд үндэслэн цөмийн болон цацраг идэвхт материал, холбогдох байгууламж, тээвэрлэлт зэрэг үйл ажиллагааны аюулгүй байдлын шаардлага, биет хамгаалалтын системийн загварыг тогтоохын тулд Загварт суурилсан аюул занал (ДВТ) эсвэл ижил төстэй аюул заналыг тодорхойлох;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК;  Бусад хариуцах байгууллага: ТEG, ЦEG болон бусад хууль сахиулах байгууллагууд;  ОУАЭА-ийн боломжит дэмжлэгээр	Хэрэгжиж байгаа	2024	
2.А.4	<b>Хяналтаас гадуурх материалын хувьд:</b> Тодорхойлсон аюул заналд үндэслэн холбогдох арга хэмжээ, хариу арга хэмжээний тогтолцоо, илрүүлэх загварыг эрэмбэлэх, мэдээлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК  Бусад хариуцах байгууллага: ТEG, ЦEG болон бусад хууль сахиулах байгууллагууд	Хэрэгжиж байгаа	2024	-

<b>2.А.5</b> <b>Олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээний хувьд:</b> Тухайн арга хэмжээтэй холбоотой учирч болзошгүй аюул, болзошгүй үр дагаварт үндэслэн хамгаалалтад авах газар болон бусад стратегийн байршлыг эрэмбэлэн, шаардлагатай нөөцийн түвшин, илрүүлэх, хариу арга хэмжээ авах зэрэг арга хэмжээг тодорхойлох.	Тэргүүлэх байгууллага: ТEG, ЦЕГ, ОБЕГ;  Бусад хариуцах байгууллага: бусад хууль сахиулах байгууллагууд	-	-	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсад хамааралтай үед тодорхой болгоно.</li> </ul>
--	--	---	---	--

### Зорилго 2.Б – Аюул занал, эрсдлийн үнэлгээг тогтмол хянаж, шинэчлэх

Арга хэмжээ	Хариуцах, үүрэг бүхий байгууллага	Явц	Төлөөлөсөн хугацаа	Тайлбар
<b>2.Б.1</b> Олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээ эсвэл тагнуулын мэдээлэл зэрэгт үндэслэн аюул занал/эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчилж баталгаажуулах, үйл ажиллагааны журмыг боловсруулах;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК;  Бусад хариуцах байгууллага: ТEG, ЦЕГ болон бусад хууль сахиулах байгууллагууд	Эхлүүлэх	2025	Үнэлгээг 2 жилд нэг удаа хийх боломжтой.  Үнэлгээ нь бусад төрлийн аюул занал/эрсдэлийн үнэлгээнээс өөр бөгөөд цөмийн аюулгүй байдлад хамаарах тусгайлан үнэлгээ байна.

### ГУРАВ. БИЕТ ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ

Хяналтад байгаа цөмийн болон цацраг идэвхт материал, холбогдох байгууламж, үйл ажиллагааны биет хамгаалалтын систем, арга хэмжээ

### 3.А Зорилго – Цөмийн болон цацраг идэвхт материал, цацраг идэвхт үсгүүрийн үндэсний тооллогыг хийж, бүртгэл хөтлөх:

Арга хэмжээ	Хариуцах, үүрэг бүхий байгууллага	Явц	Төлөөлөсөн хугацаа	Тайлбар
<b>3.А.1</b> Тооллогын мэдээллийг бүртгэх, шинэчлэх журмыг бий болгох: а. Цөмийн материал б. Цацраг идэвхт материал	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ;	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс "Цөмийн материалыг бүртгэх, хянах журам"-ыг Засгийн газрын 2020 оны 229 дүгээр тогтоолоор баталсан.</li> <li>Монгол Улс цацраг идэвхт материалын бүртгэлд RAIS+ системийг ашиглахаар төлөвлөж байна.</li> </ul>

Албан хэрэгцээнд

		Бусад хариуцах байгууллага: Холбогдох яам, агентлагууд, ОУАЭА-ийн боломжит дэмжлэгээр			<ul style="list-style-type: none"> <li>• ОУАЭА нь Монгол Улсад хуучин бүртгэлийн системийн мэдээллийг шинэ систем (RAIS+)-д шилжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</li> </ul>
<b>3.А.2</b>	Өнөөгийн бүртгэл/тооллогыг хийх: а. Цөмийн материал б. Цацраг идэвхт материал	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ; Бусад хариуцах байгууллага: Холбогдох яам, агентлагууд	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>• <b>3.А.1-ийг харгах</b></li> </ul>
<b>3.А.3</b>	Цөмийн болон цацраг идэвхт материалын өнөөгийн бүртгэл/тооллогыг тогтмол баталгаажуулах журмыг бий болгон, хэрэгжүүлэх;	ЦЭК, БШУЯ	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>• Журрамд цөмийн материалын хяналт, бүртгэлийн талаарх мэдээлэл солилцохтой холбоотой асуудлыг зохицуулсан.</li> <li>• Цацраг идэвхт материалын хувьд "RAIS+"-ийг нэвтрүүлсний дараагаар журмыг батална.</li> <li>• БШУЯ-наас бүх үүсгүүрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ирүүлсэн мэдээллийн дагуу жил бүр бүртгэдэг.</li> <li>• Одоогоор бүртгэлийн талаарх мэдээллийг БШУЯ, ЦЭК албан бичгээр дамжуулж солилцож байна.</li> </ul>

**Зорилго 3.Б – Ашиглалт, хадгалалтад байгаа цацраг идэвхт үүсгүүр болон цацраг идэвхт материалын аюулгүй байдлыг хангах зохих үр дүнтэй биет хамгаалалтын арга хэмжээ болон төлөвлөх, бий болгох, тогтвортой байлгахад эрсдэлд суурилсан хандлагыг ашиглах:**

	<b>Арга хэмжээ</b>	<b>Хариуцах, үүрэг бүхий байгууллага</b>	<b>Яц</b>	<b>Төлөөлсөн хугацаа</b>	<b>Тайлбар</b>
<b>3.Б.1</b>	Аюул заналын үнэлгээ эсвэл Загварт суурилсан аюул заналын үнэлгээнд үндэслэн холбогдох байгууламж, үйл ажиллагаа эсвэл бусад байршилд биет хамгаалалтын арга хэмжээ, аюулгүй байдлын төлөвлөгөөг бий болгон,	Тэргүүлэх байгууллага: ЦЭК; Бусад хариуцах байгууллага:	Тогтмол	Тогтмол	<ul style="list-style-type: none"> <li>• АНУ-ын ЭХЯ-наас зарим объектын биет хамгаалалтыг сайжруулах техникийн дэмжлэг авсан.</li> <li>• Загварт суурилсан аюул заналын үнэлгээнд үндэслэн ХСҮТ, ЦЭК-ын Изотоп контор, МУИС-ийн Цөмийн физикийн судалгааны төвд биет</li> </ul>

	Тогтвортой байлгаж, хяналт тавьж, шаардлагад нийцсэн эсэхийг үнэлэх;	Холбогдох яам, агентлагууд; АНУ-ын Сандиагийн үндэсний лаборатори			<ul style="list-style-type: none"> <li>Хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</li> <li>Монгол Улс АНУ-ын Цөмийн аюулгүй байдлын газар болон Сандиагийн үндэсний лабораторитой хамтран харуу арга хэмжээтэй холбоотой цуврал сургалтуудыг зохион байгуулсан.</li> <li>ШУА-ийн ФТХ-гийн цацраг идэвхт үсгүүрийн биет хамгаалалтыг хангахад АНУ-ын Сандиагийн үндэсний лабораториос дэмжлэг авах боломжтой.</li> </ul>
3.Б.2	Цацраг идэвхт материал, холбогдох байгууламж, үйл ажиллагааны биет хамгаалалтын систем, арга хэмжээний талаарх сургалтын шаардлагыг тогтоох;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК; ОУАЭА	Хэрэгжиж байгаа	Тогтмол	<ul style="list-style-type: none"> <li>Цацрагийн үсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрэмд Цөмийн аюулгүй байдлын сургалттай холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг.</li> <li>2023 оны 07 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотноо зохион байгуулагдах Цацраг идэвхт материалын аюулгүй байдлын ажлын хэсгийн XI бага хурал (жилийн хурал) болон дараа дараагийн хуралдаанд Монгол Улс оролцох боломжтой.</li> <li>Монгол Улс Цацраг идэвхт материалын аюулгүй байдлын чиглэлээр сургалт хүлээн авах хүсэлт хүргүүлэх боломжтой (NSS-11-д суурилсан).</li> </ul>
3.Б.3	Ур дүнтэй биет хамгаалалтын арга хэмжээнүүдийн шаардлагатай засвар үйлчилгээ, найдвартай ажиллагааг хангахын тулд техникийн үнэлгээг тогтмол хийж, шаардлагатай тохиолдолд шинэчлэх;	ЦЭК, БШУЯ	Тогтмол	Тогтмол	<p>Дээрх гурван байгууламжийн биет хамгаалалт, ашиглалтын засвар үйлчилгээг АНУ-ын ЭХЯ-тай гэрээлэгч компани тухайн байгууламжийн операторуудтай хамтран гүйцэтгэдэг. Гэрээлэгч компанийн гэрээний хугацаа дуусахад операторууд засвар үйлчилгээг харууцна.</p> <p>Аюулгүй байдлын бүх үйл ажиллагааг операторууд аюулгүй байдлын төлөвлөгөөнд тусгадаг. БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар эрсдэлийн үнэлгээ (Зэрэглэсэн хандлага)-нд үндэслэн жил бүр хяналт шалгалт хийх төлөвлөгөө баталдаг.</p>
3.Б.4	Ашиглагдаагүй цацраг идэвхт материал, ашиглагдахгүй болсон цацраг идэвхт үүсгүүр, хяналтаас гадуур олдсон үүсгүүр, хурааж аюулгүй болгосон материалд дараахь нэг буюу хэд хэдэн зүйлийг	Тэргүүлэх байгууллага: ЦЭК;	Хэрэгжиж байгаа		<p>БШУЯ Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар эзэнгүй үүсгүүрийг эрэн хайх, аюулгүй болгох үйл ажиллагаанд оролцдог.</p>

<p>багтаасан зохицуулах үндэсний бодлого, стратегийг бий болгох.</p> <p>1- Нийлүүлэгчид буцаах (эцсийн хэрэглэгч/нийлүүлэгч) боломжгүй тохиолдолд:</p> <p>2- Урт хугацаанд хадгалах:</p> <p>а. Ашиглагдаагүй цацраг идэвхт материал, ашиглагдахгүй болсон цацраг идэвхт үүсгүүр, хяналтаас гадуур олдсон үүсгүүр, хурааж аюулгүй болгосон материалд тохирох биет хамгаалалтын элемент бүхий аюулгүй хадгалах байгууламж (ууд)-ыг бий болгох/тодорхойлох:</p> <p>б. Ашиглагдаагүй цацраг идэвхт материал, ашиглагдахгүй болсон цацраг идэвхт үүсгүүр, хяналтаас гадуур олдсон үүсгүүр, хурааж аюулгүй болгосон материалыг аюулгүй хадгалах байгууламж руу шилжүүлэх арга хэмжээ авах:</p> <p>с. Үйлдвэрлэгч улс руу нь буцаах:</p>	<p>Бусад харилцах байгууллага:</p> <p>Холбогдох яам, агентлагууд:</p> <p>ОУАЭА</p>		<p>Эзэнгүй үүсгүүрийг ОБЕГ (аврах бригад) болон БШУЯ-наас аюулгүй болгож ЦЭК-ын Изотоп конторт хадгална. Эзэнгүй үүсгүүрийг эрэн хайх, аюулгүй болгох төлөвлөгөөний төслийг боловсруулсан ба зөвлөмж болгон ашиглах боломжтой.</p> <p>Монгол Улс ОУАЭА-ийн Ашиглагдахгүй болсон битүү цацраг идэвхт үүсгүүрийн II шатны төсөлд оролцсон, дэмжлэг хүлээн авах боломжтой.</p> <p>2022 оны 11 дүгээр сарын 07-11-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод зохион байгуулагдсан Ашиглагдахгүй болсон битүү цацраг идэвхт үүсгүүрийн II шатны төслийн анхдугаар техникийн уулзалтад Монгол Улс цахимаар оролцсон.</p> <p>Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу ашиглагдахгүй болсон үүсгүүрийг ЦЭК-ын Изотоп конторт хадгалж эсвэл нийлүүлэгчид буцаадаг.</p> <p>Ашиглагдахгүй болсон үүсгүүрийн менежментийн чиглэлээр ОУАЭА-аас дэмжлэг үзүүлэхийг хүссэн.</p>
---	--	--	--

**Зорилго 3.В – Цөмийн болон цацраг идэвхт материалын дотоод болон олон улсын тээвэрлэлтэд биет хамгаалалтын тохирох, үр дүнтэй арга хэмжээг төлөвлөх, бий болгох, тогтвортой байлгахад эрсдэлд суурилсан хандлагыг ашиглах:**

<b>Арга хэмжээ</b>	<b>Харууцах, үүрэг бүхий байгууллага</b>	<b>Явц</b>	<b>Төлөөлсөн хугацаа</b>	<b>Тайлбар</b>
<p><b>3.В.1</b></p> <p>Тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой аюул заналын үнэлгээ/загварт суурилсан аюул заналын үнэлгээнд үндэслэн цөмийн болон цацраг идэвхт материалын тээвэрлэлттэй холбоотой биет хамгаалалтын арга хэмжээг бий болгох/хэрэгжүүлэх, тогтвортой байлгах, хяналт тавих:</p>	<p>Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ЦЕГ, ЦЕГ;</p> <p>Бусад харилцах байгууллага: ЗТХЯ, хэрэглэгч байгууллагууд;</p>	Тогтмол	Тогтмол	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 243 дугаар тогтоолоор "Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журам"-ыг баталсан. Энэхүү журам нь аюулгүй ажиллагаанд илүү хамаарч байгаа боловч аюултай материалыг тээвэрлэхтэй холбоотой бусад дүрэм журмуудыг зааж өгсөн байдаг.</li> <li>Автотээврийн үндэсний төв нь цацраг идэвхт бодис тээвэрлэх хэрэгслийг шалгадаг.</li> </ul>

		ОУАЭА			<ul style="list-style-type: none"> <li>• Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу цацраг идэвхт материал тээвэрлэх тусгай зөвшөөрлийг БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар олгодог.</li> <li>• БШУЯ-ны хяналт шалгалтын хуудаст тээвэрлэлтийн аюулгүй байдал, биет хамгаалалттай холбоотой асуултууд багтсан байдаг.</li> <li>• Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрэмд тээвэрлэлтийн үед аюулгүй байдлыг сулруулахгүй байх буюу биет хамгаалалтыг ижил түвшинд хийхээр заасан. Мөн сав, баглаанд тавигдах шаардлагыг тодорхойлсон.</li> <li>• ЦЭК АНУ-ын ЭХЯ, Сандиагийн үндэсний лабораторитой хамтран “Тээвэрлэлтийн үеийн хариу арга хэмжээ” сэдэвт сургалтыг 2021 оны 09 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулсан.</li> <li>• Монгол Улс 2023 оны IV улиралд Нидерланд улсын Амстердам хотноо зохион байгуулагдах “Цацраг идэвхт материалын тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал” сэдэвт олон улсын сургалтад оролцох боломжтой.</li> <li>• Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрэмд тодорхойлсон зэрэглэсэн хандлагын дагуу аюулгүй байдлын А, В ангилалд тээвэрлэлтийн аюулгүй байдлын төлөвлөгөө шаардлагатай. Төлөвлөгөөг БШУЯ-наас хоёр жил тутамд хянаж, үнэлдэг.</li> </ul>
<b>3.В.2</b>	Холбогдох материалын тээвэрлэлтийн ангилалд үндэслэн цөмийн болон цацраг идэвхт материалд хамаарах тээвэрлэлтийн аюулгүй байдлын төлөвлөгөөг шаардан, хянаж, багтлах;	БШУЯ болон хэрэглэгч байгууллагууд	Тогтмол	Тогтмол	
<b>3.В.3</b>	Тээвэрлэлтийн аливаа үйл ажиллагаа явуулахаас өмнө Эрх бүхий байгууллага(ууд) болон операторуудын хооронд аюул заналын үнэлгээний өөрчлөлтийн талаар мэдээлэл солилцох механизмыг бүрдүүлэх;	БШУЯ;	Биелсэн	Биелсэн	<ul style="list-style-type: none"> <li>• Эрх бүхий байгууллага, операторуудын хооронд аюул заналын үнэлгээнд гарсан аливаа өөрчлөлтийг дамжуулах механизмын тухай хууль тогтоомж/дүрэм журамд тодорхой заалт байдаггүй. Гэсэн хэдий ч цагийн байдал болон аюул заналын үнэлгээнд үндэслэн шаардлагатай аюулгүй байдлын арга хэмжээг операторуудад мэдэгддэг.</li> </ul>

<b>3.B.4</b>	Цөмийн болон цацраг идэвхт материалын тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын сургалтын шаардлагыг тогтоох;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК; ОУАЭА, АНУ-ын Цацрагийн аюулгүй байдлын газар	Биелсэн	Биелсэн	<ul style="list-style-type: none"> <li>Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрэм нь тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын сургалтын шаардлагыг тодорхойлсон байдаг.</li> <li>Цөмийн энергийн комиссын дүрэмд мөн сургалттай холбоотой тодорхой заалтуудыг тусгасан байдаг.</li> <li>ОУАЭА-ийн тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын чиглэлээр зохион байгуулах сургалтуудад оролцох боломжтой.</li> <li>АНУ-ын Цөмийн аюулгүй байдлын газраас тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын харилцаа хэмжээний сургалтыг Монгол Улсад зохион байгуулах боломжтой.</li> </ul>
<b>3.B.5</b>	Тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлж, шаардлагатай тохиолдолд шинэчлэх;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ЦЕГ; Бусад хариуцах байгууллага: ЗТХЯ; ОУАЭА	Эхлүүлэх	2024	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын үндэсний үйл ажиллагааг дүгнэх асуудлаар ОУАЭА-ийн экспөртүүдийн дэмжлэгийг хүсэх боломжтой.</li> <li>2021 онд АНУ-ын Сандиагийн үндэсний лабораторитой хамтран "Тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал сэдэвт" цахим сургалт зохион байгуулсан.</li> <li>Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд АНУ-ын ЭХЯ-ны дэмжлэгтэйгээр аюулгүй байдлын бусад сургалтуудыг зохион байгуулсан.</li> </ul>

**ДӨРӨВ. ХЯНАЛГААС ГАДУУРХ МАТЕРИАЛТАЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ БОЛОН ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ҮЙЛДЛИЙГ ИЛРҮҮЛЭХ**

**Зорилго 4.А – Цөмийн аюулгүй байдлын илрүүлэх систем, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх үндэсний шийдвэр гаргах**

	<b>Арга хэмжээ</b>	<b>Хариуцах, үүрэг бүхий байгууллага</b>	<b>Явц</b>	<b>Төлөөлөгсөн хугацаа</b>	<b>Тайлбар</b>
<b>4.А.1</b>	Аюулгүй байдлын өргөн хүрээний бодлого, стратегийн дагуу цөмийн аюулгүй байдлын тогтолцоо, арга хэмжээг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэххууль, эрх зүйн орчинг бий болгох;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ГЕГ; Бусад хариуцах байгууллага:	Хэрэгжиж байгаа	2023	<ul style="list-style-type: none"> <li>Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу Гаалийн ерөнхий газар нь хилийн хяналтын асуудлыг хариуцна.</li> <li>Холбогдох байгууллагуудын эрх, үүргийн талаар илүү нарийвчилсан баримт бичиг боловсруулах шаардлагатай.</li> </ul>

		ХХЕГ, ТЕГ, ЦЕГ, ОУАЭА			<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын Хилийн тухай хуулийн 16 дугаар зүйлд хилийн хяналтын төхөөрөмжүүдээр зорчигчдыг шалгах тухай заасан байдаг.</li> <li>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр тогтоолоор Монгол Улсын хилийн боомтуудад цөмийн материал, цацрагийн үүсгүүр болон цацраг идэвхт материалын хууль бус хөдөлгөөнийг хянах зорилгоор сууриллуулсан цацрагийн хяналтын төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцан ажиллахыг Гаалийн ерөнхий газарт даалгасан.</li> <li>Монгол Улсын 26 хилийн боомт цацраг идэвхт изотоп илрүүлэх, таних багажаар хангагдсан. Энэ чиглэлээр ГЕГ, БШУЯ, ХХЕГ хамтран ажилладаг.</li> <li>Суурин мониторингуудад засвар үйлчилгээ хийх, шинэчлэх шаардлагатай.</li> <li>Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, цөмийн аюулгүй байдлыг хангах, цацраг идэвхт материалыг илрүүлэх зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээг тусгах шаардлагатай.</li> <li>Цөмийн аюулгүй байдлын үндсэн элементүүдийн тухай ОУАЭА-ийн олон улсын сургалтад холбогдох албан хаагчдыг оролцуулах боломжтой.</li> </ul>
--	--	-----------------------------	--	--	---

**Зорилго 4.Б – Эрсдэлд суурилсан үндэсний илрүүлэх стратегийг боловсруулах:**

	<b>Арга хэмжээ</b>	<b>Хариуцах, үүрэг бүхий байгууллага</b>	<b>Явц</b>	<b>Төлөөлөгсөн хугацаа</b>	<b>Тайлбар</b>
<b>4.Б.1</b>	Аюул занал, эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн хяналтаас гадуурх материалыг илрүүлэх үндэсний стратегийн зорилго, хамрах хүрээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, үндсэн үүрэг, хариуцлага, зохицуулалтын механизмыг тодорхойлох;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ГЕГ; Бусад хариуцах байгууллага: ХХЕГ, ТЕГ, ЦЕГ;	Хэрэгжиж байгаа	2024	<ul style="list-style-type: none"> <li>2016 онд ОУАЭА-ийн экспертүүдийн ажлын хэсэг Монгол Улсын цөмийн аюулгүй байдлын илрүүлэх чадварыг үнэлж, илрүүлэх стратегийн элементүүдийг боловсруулсан.</li> <li>Монгол Улс илрүүлэх үндэсний стратегийг боловсруулахад ОУАЭА-аас дэмжлэг авах боломжтой.</li> <li>Үндэсний илрүүлэх стратегийг боловсруулах туршлага судлах зорилгоор бусад улс (Малайз</li> </ul>

	ОУАЭА			Улс, ОХУ, АНУ, Тайландын Хаант Улс, БНХАУ)-д танилцах дадлага хийх боломжтой. Үндэ ОУАЭА дэмжлэг үзүүлнэ.	
<b>4.Б.2</b>	Тодорхойлсон илрүүлэх стратегийг албажуулан, баталж, холбогдох талуудад хүргэх;	Тэрлүүлэх байгууллага: ЦЭЖ	Эхлүүлэх	2024	• 4.Б.1-ээс хамаарна.
<b>4.Б.3</b>	Үндэсний стратегийг олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээ зэрэгтэй уялдуулан тогтмол хянаж байх;	Тэрлүүлэх байгууллага: ЦЭЖ, БШУЯ, ГЕГ; Бусад хариуцах байгууллага: ХХЕГ, ТЕГ, ЦЕГ	Эхлүүлэх	-	• 4.Б.1, 4.Б.2-оос хамаарна.

**Зорилго 4.В – Илрүүлэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх: Цөмийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цацраг идэвхт материалыг илрүүлэх зохицуулалт, зохион байгуулалтыг<sup>1</sup> төлөвлөх, бий болгох, тогтвортой хөгжүүлэх:**

	Арга хэмжээ	Хариуцах, үүрэг бүхий байгууллага	Явц	Төлөвлөсөн хугацаа	Тайлбар
<b>4.В.1</b>	Илрүүлэх стратегийн зорилго, тэрлүүлэх чиглэл, хуваарилгдсан чадавх, нөөцөд нийцсэн Цөмийн аюулгүй байдлыг хангах, цацраг идэвхт материалыг илрүүлэх зохицуулалт, зохион байгуулалтын төлөвлөгөөг баталгаажуулах;	Тэрлүүлэх байгууллага: ЦЭЖ, БШУЯ, ГЕГ; Бусад хариуцах байгууллага: ХХЕГ, ТЕГ, ЦЕГ	Эхлүүлэх	2024	-
<b>4.В.2</b>	Биет болон хүний, санхүүгийн нөөцийн хэрэглээг тодорхойлж, олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээнээс хамаарч илрүүлэх стратегийг хянаж, өөрчлөхөд хүрсэн тохиолдолд илрүүлэх арга хэмжээг үр дүнтэй, тогтвортой	Тэрлүүлэх байгууллага: ЦЭЖ, БШУЯ, ГЕГ;	Эхлүүлэх	2025	-

<sup>1</sup> Хяналтаас гадуурх цөмийн болон цацраг идэвхт материалыг илрүүлэх үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цөмийн аюулгүй байдлын хууль эрх зүйн болон хяналтын тогтолцооны нэгдсэн систем буюу арга хэмжээ

	хэрэгжүүлэхийн тулд нөөцийг эрэмбэлэх, хуваарилах;	Бусад хариуцах байгууллага: ХХЕГ, ТЕГ, ЦЕГ	Эхлүүлэх	-	
4.В.3	Илрүүлэх үйл ажиллагааны загвар, төлөвлөгөө болон журмуудыг боловсруулж, олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байгаа тохиолдолд дахин хянаж үзэх;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ГЕГ; Бусад хариуцах байгууллага: ХХЕГ, ТЕГ, ЦЕГ	Тогтмол	Тогтмол	<ul style="list-style-type: none"> <li>• ХХЕГ зэрэг байгууллагуудын эхний хариу арга хэмжээ үзүүлэгч албан хаагчдыг илрүүлэх арга техникт сургах, сургагч багш бэлтгэх;</li> <li>• Хилийн мониторинг ГЕГ-т шилжсэнтэй холбогдуулан тухайн байгууллагын албан хаагчдыг бэлтгэх, сургаж дудлагажуулах;</li> <li>• Илрүүлэх тоног төхөөрөмж, ялангуяа тунгийн чадлын хэмжих хэрэгсэл болон изотоп таних хэмжих хэрэгслийг шинээр авах/солжих;</li> </ul>
4.В.4	Тодорхойлсон үйл ажиллагааны төлөвлөгөө, журмууд болон бэлэн нөөцтэй нийцүүлэн илрүүлэх чадварыг бий болгох, хөгжүүлэх, хэрэгжүүлэх: а. Сургалтын хөтөлбөр, хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ГЕГ; Бусад хариуцах байгууллага: ХХЕГ, ТЕГ, ЦЕГ; ОУАЭА	Тогтмол	Тогтмол	<ul style="list-style-type: none"> <li>• 2024 оны 10 дугаар сарын 01-03-нд Египет Улсын Каир хотноо болох эхний хариу арга хэмжээ үзүүлэгчдийн сүлжээний олон улсын IV уулзалтад холбогдох албан хаагчийг оролцуулах боломжтой.</li> </ul>
	6. Илрүүлэх технологи, аргачлал:	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ГЕГ; Бусад хариуцах байгууллага: ХХЕГ, ТЕГ, ЦЕГ; ОУАЭА	Тогтмол	Тогтмол	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын ажиллагаатай 26 хилийн боомт изотоп таних төхөөрөмжөөр тоноглогдсон. БШУЯ, ХХЕГ энэ хүрээнд хамтран ажилладаг.</li> <li>• Илрүүлэх тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээ, шинэчлэлтүүд хийгдэж байна.</li> <li>• Зөөврийн цацрагийн хэмжих хэрэгсэл болон изотоп таних төхөөрөмж шаардлагатай.</li> <li>• АНУ-ын ЭХЯ-тай хилийн цацрагийн хяналтын мониторингуудыг суурилуулахтай холбоотой санамж бичгийг 2007 онд байгуулсан.</li> <li>• 2008-2013 онд 15 хилийн боомтыг тээврийн хэрэгслийн цацрагийн хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон. 2018 онд онгоцны будлуудад хүн</li> </ul>

			Хэрэгжиж байгаа	2026	<p>болон бараа шалгах төхөөрөмжүүдийг суурилуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• ОУАЭА-аас 2017 онд Монгол Улсын хууль сахиулах хяналтын байгууллагуудад 4 ширхэг гамма/нейтрон цацраг хэмжих хэрэгсэл бүхий спектрометр, 2 ширхэг гамма/нейтрон цацраг хэмжих хэрэгсэл бүхий цацраг идэвхт изотоп таних зориулалт бүхий тоног төхөөрөмж олгосон.</li> <li>• 2018 онд БШУЯ гамма спектрометр авсан. БШУЯ-наас лабораторийн тоног төхөөрөмжийн дэмжлэг хүссэн.</li> <li>• Цөмийн илрүүлэх технологийг ашиглан аюулгүй, найдвартай худалдааг хөнгөвчлөх, мөн илрүүлэх технологийн бусад хамтарсан судалгааны үйл ажиллагааг судлах зорилгоор ОУАЭА-ийн Хамтарсан судалгааны үйл ажиллагаа (СРР)-нд санал хүргүүлэх боломжтой дэлгэрэнгүй мэдээлэл болон холбоо барих мэдээллийг дараах хаягаар авах боломжтой: <a href="https://www.iaea.org/projects/crr/j02015/">https://www.iaea.org/projects/crr/j02015/</a>.</li> <li>• ОУАЭА-аас 2023 оны 02 дугаар сарын 27-ноос 03 дугаар сарын 03-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод зохион байгуулагдсан “Цөмийн аюулгүй байдалд хэрэглэгддэг цацраг илрүүлэх тоног төхөөрөмжийн сүлжээ ба харилцаа холбоо” сэдэвт техникийн уулзалтад холбогдох албан хаагчийг оролцуулсан.</li> <li>• 2018 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд ОУАЭА-аас Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод зохион байгуулсан “Илрүүлэх лабораторийн тоног төхөөрөмжийн техникийн уулзалт”-д холбогдох албан хаагчийг оролцуулсан. ЦЭК, ЦЕГ, ТЕГ-ын 5 албан хаагчийг ЦЭК болон Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудад ашиглаж буй цацраг илрүүлэгч зөөврийн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируула хийх, ажиглуулах, алдааг олж засварлах, засвар үйлчилгээ хийх чиглэлээр техникийн сургалтад хамруулсан.</li> </ul>
<b>4.В.5</b>	Цөмийн аюулгүй байдлыг дэмжих төвөөр дамжуулан тогтвортой, найдвартай, гүйцэтгэлд суурилсан үйл ажиллагааг хангахын тулд тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулах.	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ГЕГ; Бусад хармуцах байгууллага: ХХЕГ, ОУАЭА	Хэрэгжиж байгаа	2026	

					<ul style="list-style-type: none"> <li>БШУЯ илрүүлэх арга техник, илрүүлэх төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээний чиглэлээр дагалдах сургалтад хамрагдах хүсэлт гаргасан (ОУАЭА-ийн илрүүлэх лаборатори болон Исламын Бүгд Найрамдах Пакистан Улс Аюулгүй ажиглагаа аюулгүй байдлын үндэсний хүрээлэнд).</li> <li>Дагалдах сургалтууд болон ОУАЭА-ийн Мари Кюригийн тэтгэлэг зэрэгт хамрагдах боломжтой.</li> </ul>
--	--	--	--	--	--

**Зорилго 4.Г – Цөмийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цацраг идэвхт материалыг илрүүлэх зохицуулалтыг үнэлэх хөтөлбөрүүдийг бий болгох**

	<b>Арга хэмжээ</b>	<b>Хариуцах, үүрэг бүхий байгууллага</b>	<b>Явц</b>	<b>Төлөвлөсөн хугацаа</b>	<b>Тайлбар</b>
<b>4.Г.1</b>	Илрүүлэх зохицуулалтын хүрээнд дасгал сургуулигтын хөтөлбөрийг багтаасан үнэлгээний хөтөлбөрийг бий болгох;	Тэргүүлэх байгууллага: ЦЭК, БШУЯ, ГЕГ; Бусад хариуцах байгууллага: ХХЕГ	Эхлүүлэх	2026	<ul style="list-style-type: none"> <li>4.А-В-ийн хэрэгжилтээс хамаарна.</li> </ul>
